

СЕХ-нд улсын төсвөөс 2013 онд  
санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын  
хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН  
БАЙНА

АГУУЛГА

## Тайланг бэлтгэсэн:

## ҮАГ-ЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН аудитын газрын хөрөнгө оруулалтын алба

Захирал  
С. Төмөрхүү

Аудитын менежер  
Г.Гунжидмаа

Ахлах аудитор  
С. Сэргчхорол

## ШИНЖЭЭЧ

Товчилсон үгсийн жагсаалт	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
• Ерөнхий зүйл	5
• Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулжээ	5
• Худалдан авах ажиллагааг журмын дагуу сонгожээ	5
• Хөрөнгө оруулалтыг гэрээний дагуу санхүүжүүлсэн байна	6

2014 оны 4 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 261675, 262451  
дугаарын утас, 323266  
дугаарын  
факсаар харилцана уу.

ХАЯГ

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын 4 дүгээр байр,  
Бага тойруу-6, Улаанбаатар-  
46  
Монгол Улс

**Товчилсон уг**

УИХ

Улсын Их Хурал

УАГ

Үндэсний аудитын газар

СЯ

Сангийн Яам

СЕХ

Сонгуулийн ерөнхий хороо

ТБОНӨХБАУХАТХ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр  
бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

ХХК

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

УБ

Улаанбаатар

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторт ҮАГ-аас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт**

Улсын төсвийн хөрөнгөөр СЕХ-нд 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг шалгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аudit хийлзээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

### **Хамарсан хүрээ**

Аудитад СЕХ-нд хийгдсэн хөрөнгө оруулалтыг шалгалаа.

### **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хууль, төсвийн тодотголоор батлагдсан хөрөнгө оруулалтын судалгааг гаргуулан авлаа.
- Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлзээ.
- СЯ-наас хөрөнгө оруулалтын талаар шаардлагатай судалгаа, материалыг гаргуулж авлаа.
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг түүвэрлэн шалгалаа.
- Хөрөнгө оруулалт ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу хийгдсэн эсэхийг түүвэрлэн шалгав.
- Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



## Улсын төсвийн хөрөнгөөр 2013 хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн

Сонгуулийн Ерөнхий хороонд улсын төсвөөс 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан

2014 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### **Ерөнхий зүйл**

1.1 Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар тус хороонд улсын төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмжид 133.8 сая төгрөг батлагдсан байна.

*Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн тоног төхөөрөмжийг судалгаагаар харуулбал,  
(сая төгрөгөөр)*

Код	Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага	Эхлэх дуусах хугацаа	2013 оны Төсвийн тухай хууль	
			Төсөвт өртөг	2013 онд санхүүжих
X.1	<b>Тоног төхөөрөмж</b>		<b>133.8</b>	<b>133.8</b>
X.1.1	Мэдээллийн технологийн төв байгуулах, техник хэрэгсэл	2012-2013	17.8	17.8
X.1.2	Компьютер, тоног төхөөрөмж	2013	116.0	116.0

1.2 Дээрх судалгаанаас үзэхэд тус хороонд улсын төсвөөс санхүүжигдэх хөрөнгө оруулалтаас мэдээлэл, технологийн төв байгуулахад (он дамжин хэрэгжиж байгаа) 13.3 хувь, комюютер, тоног төхөөрөмж худалдан авахад 86.7 хувь нь батлагдсан байна.

### **Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулжээ**

1.3 СЕХ нь 2013 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2013 оны 1 дүгээр сарын 15-нд боловсруулж, СЕХ-ны даргаар батлуулсан байна.

1.4 Үүнд, Сонгуулийн автоматжуулах төхөөрөмжийг тээвэрлэх зориулалтын чингэлэгтэй ачааны машин, үйлчилгээ үзүүлэх зориулалттай жижиг оврын автобус, албан тасалгааны тавилга худалдан авахаар тооцож Сангийн яаманд хүргүүлсэн байна.

### **Худалдан авах ажиллагааг журмын дагуу сонгожээ**

1.5 СЕХ-ны даргын 2013 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 05 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

1.6 Дээрх тоног төхөөрөмжийг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан байна.

1.7 СЕХ “Сонгуулийн автоматжуулах техник хэрэгслийг тээвэрлэх зориулалттай бүхээгтэй ачааны автомашин, үйлчилгээ үзүүлэх зориулалттай микроавтобус, албан тасалгааны болон уулзалтын өрөөний тавилга, архивын зориулалтын шүүгээ” худалдан авах тендерийн урилгыг “Өнөөдөр” сонин болон “UB Post” сонини 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дугаар, [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn) цахим хуудсаар тус тус нийтэд зарлан мэдээлсэн байна.

1.8 Тус хороо тендерийн нийт төсөвт өртөг 116.0 сая төгрөгийг 5 багц болгон задалсан байна. Үүнд,



**Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн**

- ↓ Сонгуулийн автоматжуулах тоног төхөөрөмжийг тээвэрлэх зориулалттай бүхээгтэй (чингэлэгтэй) бага оврын 1.0-1.5 тн пацтай ачааны машин 38.0 сая;
- ↓ Сонгуулийн автоматжуулах тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл зөөвөрлөх, засвар үйлчилгээ үзүүлэх зориулалттай микроавтобус 43.5 сая;
- ↓ Албан тасалгааны зориулалттай иж бүрэн тавилга 8.0 сая ;
- ↓ Архивын баримт бичиг хадгалах зориулалт бүхий шүүгээ 8.0 сая;
- ↓ Уулзалтын өрөөний иж бүрэн тавилга 18.5 сая төгрөгөөр тус тус тооцсон байна.

1.9 Тендерийн баримт бичгийг 9 компани худалдан авсан боловч 6 компани оролцоо санал ирүүлснээс багц 1, 2-т тус бүр 2, багц 3-т 3, багц 4-т 2, багц 5-д 3 компани оролцоо болсон байна.

1.10 Бага оврын бүхээгтэй ачааны автомашин (багц 1) "Киа Моторч Монгол" ХХК 37.9 сая, үйлчилгээ үзүүлэх зориулалттай бага оврын автобус (багц 2) "Монгол Хьюндай Автомотив" ХХК 42.2 сая, архивын баримт бичиг хадгалах зориулалт бүхий шүүгээ (багц 4) "Лүндаа Очир"ХХК 6.9 сая, уулзалтын өрөөний иж бүрэн тавилга ) (багц 5 "Лүндаа Очир"ХХК 17.9 сая төгрөгөөр тус тус шалгарсан байна.

1.11 Харин албан тасалгааны иж бүрэн тавилга (багц 3) нийлүүлэхээр 3 компани санал ирүүлсэн боловч шаардлага хангагдаагүй учраас 2013 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр дахин тендер зарлаж, 6 компани тендерийн баримт бичгийг худалдан авч, 2 компани оролцож "БСБ мебель" ХХК 7,1 сая төгрөгт шалгарчээ.

1.12 Албан өрөөний иж бүрэн тавилга худалдан авах тендерт оролцох урилгыг 4 компанид хүргүүлснээс 2 компани санал ирүүлж, "БСБ мебель" ХХК 16,9 сая төгрөгт гүйцэтгэхээр шалгарчээ.

*Хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагаа, хэрэгжилтийг зохион байгуулсан байдлыг дараах судалгаагаар харуулбал,*  
(сая төгрөгөөр)

Батлагдсан төсөл, арга хэмжээ	Тендер шалгаруулалт НТ	Харьцуулалт	Шууд	Төсөл, арга хэмжээ (багц)	Тоног төхөөрөмж	Хугацаандаа хэрэгжээгүй арга хэмжээ
2	5	1	-	6	133.8	

1.13 Эндээс харахад нээлттэй тендер шалгаруулалтаар 5, харьцуулалтын аргаар 1 удаа худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

#### **Хөрөнгө оруулалтыг гэрээний дагуу санхүүжүүлсэн байна**

1.14 СЕХ хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд шалгарсан компани, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуу санхүүжилтийг Сангийн яамнаас авч, тухайн байгууллагуудад хүргүүлжээ.

1.15 2013 оны төсвийн тухайн хуулиар тус хороонд тоног төхөөрөмж худалдан авахаар батлагдсан 133.8 сая төгрөгөөс 129.0 сая төгрөгийг зарцуулж, 4.8 сая төгрөг хэмнэсэн байна.

1.16 Хөрөнгө оруулалтаар худалдан авсан автомашин, автобус, албан тасалгаа, архив, уулзалтын өрөөний тавилга, эд хогшлыг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.



228

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр  
дүн

- 1.17 Сангийн яамнаас худалдан авах ажиллагааны 2013 оны хэрэгжилтэд өгсөн үнэлгээгээр тус хороо нь “хангалтгүй” үнэлгээ буюу 47 оноо авсан байна.
- 1.18 Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хугацаанд нь гаргаагүй, бичмэл тайлан ирүүлээгүйтэй холбоотой байна.
- 1.19 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Хөрөнгө оруулалтад зөрчил дутагдал илрээгүй болно.

Бичсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын  
Ахлах аудитор *С.Сар* С.Сэрчхорол  
Аудитор *С.Онц* С.Одонцэцэг

Танилцаж зөвшөөрсөн:

СЕХ-ны ажлын албаны  
дарга *Д.Баяндүүрэн* Д.Баяндүүрэн